

## МОНГОЛЫН ОРЧИН ҮЕИЙН УРАН ЗОХИОЛ БА ДАЙН БАЙЛДААН

К.Окада<sup>1</sup>

1

Монгол<sup>2</sup> дахь “дайн байлдаан”-ы имиж (дүр төрх) 1939 оны “Халх голын дайн”-аар бүрэлдэн тогтжээ. Энэ дайныг Японд “Номонханы хэрэг явдал” гэж нэрлэсэн нь “Манж го” улс, Монгол улс хоёр, өөрөөр хэлбэл, энэ хоёр улсыг бүх талаас дэмжиж байсан Япон улс, ЗХУ хоёрын хоорондын хил хязгаараар үүссэн “орон нутгийн хязгаардмал тулалдаан” юмуу “хилийн будлиан” хэмээх утгыг агуулсан байна. Харин Монголд бол улс орных нь хувь заяатай шууд холбоотой “бүх хүчээ дайчилсан дайн” байжээ. Бас 1924 онд байгуулагдсан БНМАУ-ын хувьд “хүлээн зөвшөөрөгдсөн тусгаар тогтносон улс (nation-state)”-ын нэрээр байлдсан анхны болон цорын ганц дайн байсан гэж хэлж болох юм. Халх голын дайны ялалт нь Монголын эрх чөлөө, тусгаар тогтнолыг батлан хамгаалж, олон улсын байр суурийг нь бэхжүүлсэн билээ.

Тэгвэл Монголын орчин үеийн уран зохиолд энэхүү дайн байлдааныг хэрхэн дүрслэн харуулж ирсэн бэ? БНМАУ-д хамгийн нэр хүндтэй утга зохиолын шагнал бол “Төрийн шагнал” юм. 1939 онд бий болсон ЗХУ-ын “Сталины нэрэмжит шагнал”-ыг дуурайж 1945 онд бий болгосон “Маршал Х.Чойбалсангийн нэрэмжит шагнал”-ыг дарангуйлан захирагч Х.Чойбалсанг тахин шүтэх явдлыг шүүмжилсний дараа 1962 онд “Төрийн шагнал” нэртэй болгожээ. Социализмыг халж 1992 онд байгуулсан шинэ Монгол улсад ч “Төрийн шагнал” нэр хүндтэй утга зохиолын шагнал хэвээр байна. Гийм учраас Төрийн шагналт зохиол байх эсэх нь цаг үе, улс төрийн нөхцөл байдлыг харгалзах хэрэгтэй байлаа ч тухайн зохиолын үнэ цэнийг тогтоох нэг үзүүлэлт болно гэхэд арай хэтрүүлэг болохгүй буй за.

Халх голын дайныг сэдэв болгосон Төрийн шагналт зохиолоор дайны талбарт амь насаа алдсан эгэл нэг цэргийн ар гэрийн зовлон жаргалыг уран сайхнаар дүрсэлсэн Дэндэвийн Пүрэвдоржийн (1933-2010) “Хөх даалимбан тэрлэг” найраглал<sup>3</sup>, дайнд амь эрсдсэн баатарлаг дайчдын дурсгалд зориулж хөшөө босгосон хойч үеийнхний санал бодлыг дуулан өгүүлсэн Шаравын Сүрэнжавын (1938- ) “Ерэн баатрын дууль” найраглал<sup>4</sup> зэрэг зохиолыг дурдаж болно. Д.Пүрэвдоржийн

“- Халх голын дайн зөвхөн

Халх голын дайн байсангүй

Хайргай бүхнээ дайснаас өмөөрсөн

Хамаг ардын дайн байлаа”

1. Японы Токио Гадаад Судлалын Их Сургууль

2. Энд буй “монгол” хэмээх үг нь хуучин БНМАУ буюу одоогийн Монгол Улсыг заасан үг бөгөөд БНХАУ болон ОХУ дахь монгол үндэстний оршин суудаг газар орныг оруулаагүй болно.

3. 1969 онд “Утга зохиол урлаг” сонины 9 дүгээрт анх нийтлэгдэж, 1981 онд шагнал хүртсэн байна.

4. 1963 онд “Үнэн” сонины 281 дүгээрт анх нийтлэгдэж, 1988 онд шагнал хүртсэн байна.

хэмээн амгалан тайван уриалсан найраглал, харгис хэрцгий “самуурай”<sup>5</sup> нарын түрэмгийллээс хайрт эх орноо хамгаалахыг уриалсан эрэлхэг баатарлаг ухуулгын шүлэг цөөнгүй байсан тэр үед уран сайхан, утга уянгын өндөр чанараараа бусдаас онцгойрч байсан юм. Дашрамд дурдахад Төрийн шагналт зохиол биш боловч Халх голын дайнд хүүгийнхээ амь үрэгдсэнийг мэдэлгүй түүний эргэж ирэхийг хүлээж ядан сууж байгаа сохор өвгөний ганцаардсан үхлийг өгүүлсэн Донровын Намдагийн (1911-1984) “Үрэгдсэнийг хүлээгч” өгүүллэг<sup>6</sup>, Халх голын дайны урд жилийн намар япон цэрэгт баригдсан хилчин Доржийн амь аварч үхсэн домогт хээр морины тухай өгүүлсэн Чадраабалын Лодойдамбын (1916-1969) “Миний хээр (Хуучин цэргийн яриа)” өгүүллэг<sup>7</sup> зэрэг зохиол япон хэлэнд орчуулагдсан байна<sup>8</sup>.

Дайн байлдааны сэдэвтэй бусад Төрийн шагналт зохиолоор Эрдэнэбатын Оюуны (1918-2001) “Ах дүү нар” жүжиг<sup>9</sup>, Дашзэвэгийн Сэнгээгийн (1916-1959) “Аюуш” тууж<sup>10</sup> хоёрыг дурдаж болно. Энэ хоёр зохиол 1945 оны 8 дугаар сарын Японы эсрэг дайныг сэдвээ болгосон байна. 8 дугаар сарын 9-нд ЗХУ Японд дайн зарласны дараагийн өдөр БНМАУ ч Японд дайн зарлаж, ЗХУ-ын улаан армийг дагаж “Манж го” улс, Өвөр Монголын газар нутагт дайран оржээ. Харин БНМАУ-ын хувьд энэ дайныг Халх голын дайнтай харьцуулахад Өвөр Монгол дахь “үндэсний чөлөөлөх дайн”-ы шинж чанартай байжээ.

Э.Оюуны “Ахдүүнар” жүжиг Өвөр Монголын ах дүү ард түмнийг Японы империалистуудын дарлалаас чөлөөлсөн түүхт үйл явдлыг дүрсэлсэн бол, Д.Сэнгээгийн “Аюуш” тууж бодит баатар Лувсанцэрэнгийн Аюушийн (1922-1945) амь дүйсэн гайхамшигтай баатарлаг тулалдааныг дүрсэлсэн байна. Д.Сэнгээгийн “Аюуш” тууж социализмын үед дунд сургуулийн “Уран зохиолын унших бичиг”-т удаа дараа нийтлэгдэж, дайн байлдааны сэдэвтэй эх оронч туужийн нийтлэг хэв шинж боленоороо нэг ёсны үлгэр загварын үүрэг гүйцэтгэж ирсэн юм. Тус туужид дүрслэгдсэн “харгис догшин”, “муу самуурай” гэдэг нь япон цэргийн стереотип (тогтсон ойлголт) нь үүнээс хойш монгол уран зохиол дахь япон хүний хэв шинжит дүр болсон байна<sup>11</sup>.

2

1989 оны сүүлээс 1990 оны эхээр өрнөсөн Монголын ардчилал (Монголын перестройка гэгдэх “өөрчлөлт шинэчлэл”) Монголын улс төр, нийгэм, эдийн засагт төдийгүй, уран зохиолд ч урьд өмнө байгаагүй эрс өөрчлөлт хийсэн юм. Энэ үйл явдал япон хүний дээрх дүрд ч нааштай өөрчлөлт оруулах түлхэц болсон нь мэдээжийн хэрэг юм. Түүний нэг жишээ болгон Ринчингийн Ганбатын (1946- ) “Амьд явах хэрэгтэй” романд<sup>12</sup> дүрслэгдсэн Японы цэргийн олзлогдогч Ямадагийн дүрийн тухай энд танилцуулъя<sup>13</sup>.

1991 оны 3 дугаар сард Монголын засгийн газар дэлхийн II дайны дараа

5. Энэ “самуурай” хэмээх үг уг нь эртний Японы дайчин баатар эрийг заасан үг байсан боловч утга нь шилжээд япон цэргүүд, милитаристуудыг заасан үг болчихжээ.

6. 1962 онд “Цог” сэтгүүлийн 6 дугаарт анх нийтлэгдсэн байна.

7. 1967 онд “Уран үгсийн чуулган” сэтгүүлд анх нийтлэгдсэн байна.

8. Мацуда, Т. 1984. Учида, Т. 2003.

9. 1945 онд бичиж, 1946 онд “Уран сайханчуудад тусламж” сэтгүүлийн 1 дүгээрт анх нийтлэгдэж, мөн онд шагнал хүртсэн байна.

10. Энэ туужийн зарим бүлэг 1947 онд “Үнэн” сонины 203 дугаар, “Цог” сэтгүүлийн 1, 2, 3 дугаарт тус тус нийтлэгдсэний дараа тусгай ном болж хэвлэгдэж, мөн онд шагнал хүртсэн байна.

11. Д.Сэнгээгийн “Аюуш” туужид дүрслэгдсэн япон хүний дүрийн тухай Японд судлаач К.Ямагүчи анх задлан шинжилгээ хийсэн байна (Ямагүчи, К. 1985).

12. 1991 онд “Цог” сэтгүүлийн 3, 4 дүгээрт анх нийтлэгдэж, 1996 онд зохиолчийн “Алаг морь” түүвэрт дахин нийтлэгдсэн байна.

13. Миний бие үүний тухай урьд “Окада, К. 1999”, “Окада, К. 2004”-д дэлгэрэнгүй дурдсан байна.

## К.Окада

Монголд олзлогдож “социалист бүтээн байгуулалт”-ад дайчлагдаж байсан Японы цэргийн хоригдлуудын тухай албан ёсоор анх удаа хүлээн зөвшөөрч, албадан хөдөлмөрөөс нас барсан 1,597 хүний нэрсийн жагсаалтыг Японы талд шилжүүлж уучлал гуйсан юм. Р.Ганбатын роман нийтлэгдсэн цаг үе нь үүнтэй бараг таарч байна.

Романы үйл явдал лаг ерийн нярав хийж байгаа Хандаагийн 17 настай охин Бурмаагийн нүдээр өгүүлэх маягаар өрнөнө. Нийслэл Улаанбаатараас Хараа нутгийн лагерьд шилжиж ирсэн Японы цэргийн наяд олзлогдогсдын дотор Ямада байжээ. Олзлогдогч Ямада бол Осака хотын гадаад хэлний сургуулийн монгол хэлний ангид суралцсаны дараа 1939 оны “Номонханы хэрэг явдал”-д татагдаж, 1944 онд “Манж го”-гийн цэргийн Барга хороонд хэлмэрчээр ажиллаж байхдаа Жэхэ-д баригдсан түүхт хүн байжээ. Ямадаг анх харсан Бурмаад тэр үеийн “Матар” хэмээх хошин шог зургийн сэтгүүлд гардаг “арзгар дорсгор шүдтэй”, “хар хүрээтэй нүдний шил зүүсэн”, “жигжигхэн бөгтөр биетэй”, “хэрцгий ширүүн зантай” цэрэг хэмээх япон хүний хэв шинжит имижээс өөр, “цав цагаан яралзсан шүдтэй” эелдэг сайхан залуу гэсэн сэтгэгдэл төрсөн байна. Харин Японы муу “самуурай” хэмээх нөгөө имижийг ч өөрчилж чадаагүй байна. Гэсэн ч харилцаа холбоо нь гүнзгийрэх тутам Бурмаагийн сэтгэл хүсэл мөрөөдөл, энэрэл нигүүсэлээр улам солигдож ирнэ.

Энэхүү роман Бурмаа, Ямада хоёрын харилцаа холбоог гол болгон лагерь дэх янз бүрийн хүмүүсийн харилцаа холбоог дэлгэрэнгүй дүрсэлсэн байгаа бөгөөд лагерийн хуягуудын дарга Нямжавын “өндөр бөгтөр биетэй”, “дорсгор шар шүдтэй”, “өмхий амтай”, “хэрцгий ширүүн зантай”, “ичих нүүрэндээ илэг наасан хүн” хэмээх дүр төрх нь урьд өмнө монгол уран зохиолд дүрслэгдэж ирсэн япон хүний дүрийг санагдуулах юм. Романы төгсгөлд Нямжавд хүчиндүүлсэн Бурмаа Нямжав руу буу буудаад “Амьд явах хэрэгтэй” гэж шивнэх үзэгдлээр төгссөн байна. Тус романы нэр болсон энэ үг эх орондоо буцаах тушаал авсан Ямада Бурмаагаас салахдаа үлдээсэн сүүлчийн үг байсан юм. Тус романд сөрөг талын дүр болох Нямжавтай харьцуулахад Ямада хүнлэг энэрэнгүй сэтгэлтэй сайн залуугаар дүрслэгдсэн нь япон хүний тухай урьд урьдын дүр дүрслэлээс эрс тэс ялгаатай байна.

Эмэгтэй зохиолч Бат-Очирын Туяагийн (1937- ) бодит баримтад үндэслэж 1960-аад онд бичсэн “Хатаагүй нулимс” хэмээх хэвлэгдээгүй өгүүллэг ч монгол охин, олзлогдогч япон залуу хоёрын харилцаа холбоог дүрсэлсэн ажээ<sup>14</sup>. Энэ өгүүллэгийг эс тооцвол япон хүнийг сайн талын баатраар дүрсэлсэн зохиол үүнээс өмнө байгаагүй шиг санагдана.

Дашрамд дурьдахад киноны салбарт Японы цэргийн олзлогдогч Акира, лагерийн даргын өргөмөл охин Мөнхмаа хоёрын бүтэлгүй хайр дурлалыг дүрслэн харуулсан “Шувууд буцах намар”<sup>15</sup> хэмээх уянгын киноны Акирагийн дүр нь Монголын киноны түүхэнд анхны япон хүний эерэг талын баатрын дүр болох юм.

Япон хүний дүрийн иймэрхүү нааштай өөрчлөлт нь ардчиллын ачаар бий болсон нь мэдээжийн хэрэг. Энэ нь 1990-ээд оны эхээр өрнөсөн ардчилсан хөдөлгөөнөөр урьд өмнө утга зохиол, урлагийн цорын ганц арга барил болгон албадан шаардаж ирсэн “социалист реализм” хаягдаж, дангаар захирч ирсэн МАХН-ын захиргааны систем үгүй болсны үр дүнд зохиолчид уран бүтээлийн хатуу хоригоос чөлөөлөгдөж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ олж авсны илрэл юм.

\*2009 онд Халх голын дайны 70 жилийн ой тохиолсон билээ. Урьд Монголын Зохиолчдын Эвлэл Зөвлөлтийн Зохиолчдын Эвлэлтэй хамтран “Халх голын дайчин ах дүү нар”

14. Миний бие үүний тухай 2002 оны 8 дугаар сард Улаанбаатар хотноо хуралдсан Олон Улсын Монголч Эрдэмтний VIII Их Хурал дээр зохиолч Б.Туяа өөрөөс нь сонссон юм.

15. 1992 онд Лхагвадоржийн Балхжавын (1959- ) найруулсан уран сайхны видео кино. Киноны гол дүрүүдэл Б.Баярхүү (Акирад), С.Чимгээ (Мөнхмаад) нар тоглов (Жигжидсүрэн, Г., Цэцэг, Д. 2005, 688-р тал).

К.Окада

хэмээх дайны ялалтын ойд зориулсан зохиолын цоморлогийг 30 жилийн ой болох 1969 оноос хойш 10 жилийн ой болгон монгол, орос хэлээр хэвлүүлж ирсэн юм<sup>16</sup>. Харин социалист лагерь бутран унаснаар 60 жилийн ой (1999), 70 жилийн ойд (2009) зориулсан зохиолын цоморлог хэвлэгдээгүй билээ. Дайн байлдааны сэдэвтэй уран зохиолыг нийтлүүлэх нэг талбар ийнхүү алга болсон нь харамсалтай санагдаж байна.

---

16. 1989 оны “Халх голын дайчин ах дүү нар” цоморлог зөвхөн монгол хэлээр хэвлэгдсэн байна (Галбаяр, Г. 2010. 553-р тал).

К.Окада

## НОМЗҮЙ

### 1. Япон хэлээр

- Мацүда, Т. 1984 : “Үрэгдсэнийг хүлээгч” (Д.Намдагийн өгүүллэгийн япон орчуулга), *Монголын өгүүллэгий түүвэр - Малгайтай чоно*, Эмхтгэсэн Т.Мацүда, Х.Хасүми, Ш.Араи, Kobunsha, Tokyo, pp.5-17.
- Окада, К. 1999 : “Монгол романд дүрслэгдсэн японы олзлогдогсад - Р.Ганбатын ‘Амьд явах хэрэгтэй’ романы Ямадагийн дүрийн тухай”, *Trans-Cultural Studies*, No.2. Токиогийн Гадаад Судлалын Их Сургууль, pp.40-51.
- Үчида, Т. 2003 : “Миний хээр (Хуучин цэргийн яриа)” (Ч.Лодойдамбын өгүүллэгийн япон орчуулга), *Монголын уран зохиолд уримүй*, Эмхтгэсэн Ю.Шибаяама, К.Окада, Akashi-Shoten, Tokyo, pp.116-120.
- Ямагүчи, К. 1985 : “Д.Сэнгээгийн ‘Аюуш’ туужид дүрслэгдсэн япон хүний дүр”, *Journal of Mongolian Studies*, No.8, The Society of Mongolian Studies, Osaka, pp.78-87.

### 2. Монгол хэлээр

- Баянзул, М. 1966 : *Монголын уран зохиолын нам зүйн тойм 1921-1961 он*, II, Эрхлэсэн Ж.Дашдорж, ШУА-ийн хэвлэх үйлдвэр, Улаанбаатар.
- Баянзул, М. 1966 : *Монголын уран зохиолын нам зүйн тойм 1921-1961 он*, III, Эрхлэсэн Ж.Дашдорж, ШУА-ийн хэвлэх үйлдвэр, Улаанбаатар.
- Баянзул, М. 1970 : *Монголын уран зохиолын нам зүйн тойм 1962-1969 он*, IV, Редактор Д.Хорлоо, ШУА-ийн хэвлэх үйлдвэр, Улаанбаатар.
- Баянзул, М. 1971 : *Монголын уран зохиолын нам зүйн тойм 1962-1969 он*, V, Редактор Д.Хорлоо, ШУА-ийн хэвлэх үйлдвэр, Улаанбаатар.
- Галбаяр, Г. 2010 : “‘Халхын голын дайчин ах дүү нар’ (1969, 1979, 1989) номуудын шинэлэг үзэл санаа”, *70 Years Since the Nomonhan Incident (Battle of Khalkhyn Gol) : Collection of Treatises in the 2009 International Symposium in Ulaanbaatar*, Tokyo, Fukyosha, 543-556-р тал.
- Жигжидсүрэн, Г., Цэцэг, Д. 2005 : *Монгол киноны нэвтэрхий толь*, “Содпресс” ХХК, Улаанбаатар.
- Зандраабайдий, Х. 2001 : *Шагналт зохиолчид*, Улаанбаатар.
- Зандраабайдий, Х. 2008 : *Монголын зохиолчдын намтрын лавлах бичиг*, Эрхэлсэн Д.Цэдэв, Х.Наранхүү, З.Батхуяг, “Бемби Сан” хэвлэлийн газар, Улаанбаатар.
- Окада, К. 2004 : “Монгол романд дүрслэгдсэн японы олзлогдогсад”, *MONGOLICA*, Vol.15(36), Олон Улсын Монгол Судлалын Холбоо, Улаанбаатар, 110-125-р тал.

(2012.VIII.9. Токио хот)